


Living the LOTUS

Buddhism in Everyday Life

10
2018

VOL. 157



Уүсгэн байгуулагчийн сургаал

Хашгирах дуу хоолойны цаадахыг сонсох

“Та үхвэл таарна” гэж хүүхэд нь хэлбэл ээж нь гүн цочролд орох нь ойлгомжтой. Гэхдээ энэ нь хүүхэд яахаа мэдэхээ байгаад эцэг эхээсээ тусламж хүсэн хашгирч буй дуу хоолой юм. Үг хэл, сэтгэл хоёр заавал адилхан байдаггүй.

“Гуйгаагүй байхад яах гэж намайг төрүүлсэн юм” гэх мэтийн үгэнд уурлаж уцаарлаад байх юм бол эцэг, эхийн хувьд хараахан болоогүй байна гэсэн үг. Хүүхэд нь яагаад тэгэж хэлж байгааг бодож үзэх уужуу сэтгэлтэй байх нь эцэг эхийн хайр юм. Ийм уужуу сэтгэл байхгүй бол хэг ёг хэлсэн үгэнд автагдан уур хүрч, өөр юм бодох ч сөхөөгүй болчихдог. Миний хүүхдийн амнаас яагаад ийм

үг гарах болов гэж бодож үзэн, хүүхдийнхээ сэтгэлийн гүн дэхь бодлыг ойлгох нь Арьявал бодисадвагийн “билгийн мэлмий” юм.

Ажлаа тараад харих замдаа алжаалаа тайлж ганц хундага юм уунгаа ажлын газраа шүүмжилж, даргаа муулах хүн их харагддаг. Энэ ч гэсэн ямар нэг юм хүссэн дуу хоолой байж болно. Арьявал бодисадва ийм хүмүүсийн уурсан хашгирах дуу хоолойны цаана нуугдах жинхэнэ хүслийг сонсох хүчтэй учраас ямар ч хүнийг аварч чаддаг. Бид ч гэсэн тийм хүч чадвартай болох хэрэгтэй.

Уүсгэн байгуулагчийн сургаал 9, 16-17

Living the Lotus Vol. 157 (2018.10)

Хэвлэсэн: Рисшо Косей Кай, Олон улсын хэлтэс

Хаяг: Fumon Media Center, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo 166-8537 Japan

TEL: +81-3-5341-1124

FAX: +81-3-5341-1224

Email: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp

Ахлах редактор: Саитоо Коочироо

Орчуулсан: Ж.Гэрэлтуяа, Б. Мөнхцэцэг

Эхийг хянасан: Монголын РКК

Рисшо Косей кай байгууллага нь Уүсгэн байгуулагч Нивано Никкёо болон түүний шавь Хамтран үндэслэгч Наганүма Мёокоо нарын санаачлагаар 1938 онд байгуулагдсан ба “Гурван Эрдэнийн Цагаан Лянхуа Судар”-ыг гол сургаал номлолоо болгодог, лам бус эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл Шагжамүни бурхан багшийн сургаалыг гэр бүл, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлж, дэлхийн энх тайвныг бүтээн байгуульга гэсэн хүсэл зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Гишүүд бид бурхан багшийн шавь болохынхоо хувьд тус байгууллагын Ерөнхийлөгч Нивано Ничикоогийн удирдлага дор бурханы сургаалыг түгээх үйлсэд зүтгэж, шашны төдийгүй бусад салбарын байгууллагууд, дэлхийн олон орны хүмүүстэй сэтгэл нэгдэн, энх тайвны олон янзын үйл ажиллагаа

Living the Lotus – Buddhism in Everyday Life (Амьд Цагаан Лянхуа судар – Буддизм бидний амьдралд)” хэмээх тус сэтгүүлийн нэрэнд, Цагаан лянхуа судрын сургаалыг өдөр тутмынхаа амьдралд хэрэгжүүлж, шаварт ургадаг үзэсгэлэнт лянхуа цэцэг мэт үр бүтээмжтэй, үнэ цэнэтэй амьдралыг туулцгаая гэсэн хүсэл шингэсэн билээ. Бид энэхүү сэтгүүлээр дамжуулан өдөр тутамдаа хэрэгжүүлж болох бурханы сургаалыг дэлхийн өнцөг булан бүрт хүргэж байна.

Бурханы үйлийг хамтдаа өөдрөгөөр хэрэгжүүлье

Рисшо Косей Кай, Ерөнхийлөгч
Нивано Ничикоо



Модны навчис шаргалтах мэт

Намрын улирал ирж буй энэ цаг үеийн өнгийг шүлэг зохиогч Ёса Бүсон (1716-1784) ийнхүү шүлэглэсэн байдаг. «Сакүра цэцэг шаргалтан улайрах нь ч гэсэн юутай үзэсгэлэнтэй вэ.»

Энэ нь намар сакүра модны навч бусад модноос түрүүлж өнгөө хувирган, хагдран унадагийг дүрсэлсэн шүлэг юм. Хавар ч гэсэн сакүра мод үзэсгэлэнтэй цэцэг дэлгэрүүлээд хагдран унадаг гээд бодохоор сакүра мод өөрт оноогдсон амьдралын утга учрыг бүрэн гүйцэтгэж байгаад нь сэтгэл хөдөлнө.

Харин бид ямар нэг зүйлийн төлөө ажиллаж, өөрийгөө зориулах үед хичээх, шамдах гэсэн үг хэрэглэдэг. Тийм болохоор ч тэр үү хичээл зүтгэл, шамдах гэхээр дааж давашгүй хэцүү зүйл мэт боддог. Сүсэг бишрэлийн ертөнцөд ч гэсэн “Шамд, шамд, насан өөд болтлоо шамд, дараа төрөлдөө ч дахин шамд” гэсэн урам зориг өгөх хэллэг байдаг ба үүнийг сонсохоор зарим хүмүүст өөрийн эрхгүй дарамт мэдрэгдэж магадгүй. Гэхдээ хичээх, шамдах гэдэг нь угтаа хичээхгүй бол болохгүй, хэцүү бэрхшээлийг тэвчиж хийх гэсэн утгатай биш юм.

“Хичээх шамдах” гэдэг ханз нь хоёр ханз үсэгнээс бүтдэг ба эхний ханз нь будааг хальслан цайруулж, хоггүй цэвэр цагаан будаа болгох гэсэн утгатай байдаг. Өөрөөр хэлбэл хичээх шамдах гэдэг нь цагаан цайлган сэтгэлээр урагш тэмүүлж амьдрахыг хэлнэ. Мөн энэ ханзанд “уг үндэс”, “төрөлхийн хүч чадвар” гэсэн утга агуулдаг. Энэ утгаар нь аваад үзвэл бидний өдөр тутамдаа их хэлдэг “хичээцгээе, шамдацгаая” гэсэн үгийг “байгалиас заяасан чадвараа байгаагаар ил гаргая” гэсэн утгаар ойлгож болно.

Ингээд бодоод үзэхээр сакүра модны навч өнгөө хувирган унаж, өөрийн онцлог чадвараа байгаагаар нь илэрхийлж байгаа байгалийн үзэгдэл ч гэсэн бүгд “хичээх шамдах” гэж юу гэсэн үг болохыг харуулж байгаа мэт. Бид ч гэсэн үргэлжийн өөрчлөгдөн шинэчлэгдэж байдаг байгалийн нэг хэсэг учраас “байгаль ертөнцийн жам ёсны дагуу амьдрах” нь өөрөө хичээл зүтгэл буюу “Хутагтын найман зөв зам” сургаалын “Зөв тэмүүлэл” юм.

Жинхэнэ өөрийгөө олох

Мод ургамалаас ялгаатай нь хүмүүс бидэнд өөрийгөө бодсон сэтгэл байдаг. Дуртай дургүй, сайн муу гэсэн хувь хүний үнэлэмж байдаг тул аливаа зүйлийг байгаагаар нь хүлээж авч чадахгүй үе байдаг. Тийм үед ямар нэгэн аргаар сэтгэлээ ертөнцийн хуулийн дагуу залахыг хичээхийг “хичээх, шамдах” гэж хэлнэ. Сэтгэлээ хэрхэн залах талаар Шагжамүни будда дараах олон янзын сургаал айлдсан байдаг:

Сүсэг бишрэл нь миний тарих үр бол түүнийг дэлгэрүүлэх зүйл нь бороо юм.

Билиг оюун нь анжис бол санаа зовох сэтгэл нь анжисны тэнхлэг юм.

Сэтгэл нь холбогч олс бол өөрийгөө дүгнэх нь анжисны ир юм.

Бие, үг хэлээ цэгнэж, хоолоо тохируулан, хэтрүүлж идэхгүй байх.

Жинхэнэ үнэний хуулийг баримтлах нь өвс хадахтай адил.

Уян хатан байх гэдэг нь морины аргамжааг суллахтай адил..


Эдгээр зүйр үгийг би «Сэтгэлээ сайжруулах» номондоо ч гэсэн дурьдсан. Энд гарч буй “ичих сэтгэл”, “өөрийгөө дүгнэх”, “бие, үг хэлээ цэгнэх”, “хэтрүүлж идэхгүй байх”, “жинхэнэ үнэний хуулийг баримтлах”, “уян хатан байх” гэсэн сургаалаар дамжуулж хувиа хичээсэн зөрүүд зангаа дүгнэж цэгнэн, жинхэнэ өөрийгөө олох чухал. Мэдээж хэрэг эдгээрийг ч гэсэн хийхгүй бол болохгүй гэж хийх биш, хамтдаа сонирхолтойгоор хэрэгжүүлж байна гэж хүлээн авах хэрэгтэй.

Үг хэлээ жоохон л цэгнэснээр уур амьсгал сайхан болж, уян хатан харилцаагаар дамжуулж хүний сэтгэлийг зөөлрүүлж болдог. Мөн гэдсээ дүүртэл идэхгүй байх нь биед хөнгөн байдгийг хэн хүнгүй мэдэх байх.

Дээр үед дээрх зүйр үгсийг яг л хуулчихсан юмуу гэмээр “Өдөр бүр «зөв тэмүүлэл»-тэй амьдрах” гэсэн нийтлэлийг байгууллагын сэтгүүлээс уншиж байсан ба тэнд “хүнийг баярлуулах үйл хийе”, “хүний итгэлийг олъё”, “өөрөөсөө ичихгүй байхаар амьдарья”, “хүнд эелдэг нинжин сэтгэлээр хандъя”, “уур уцаараа барья” гэх мэтчилэн бичсэн байсан. Тэр үед эдгээрийг өдөр бүр дахин дахин өөртөө хэлж сонсгон өөртөө дүгнэлт хийж, бурханы зам мөрөөр алхах баяр хөөрөө хуваалцдаг байж билээ. Өөрөөр хэлбэл зөв тэмүүлээр хичээж, шамдсанаар жинхэнэ өөрийгөө олж авах баяр хөөрийг мэдэрдэг байсан юм. Жинхэнэ өөрийгөө олох гэдэг нь бурханлаг чанараа олж анзаарахыг хэлж байгаа билээ.

“Косей” сэтгүүл 10-р сарын дугаараас





Лянхуан Гурамсан Сударын бүлэг тус бүрийн тайлбар

Оройн Дээд Цагаан Лянхуа Судар Уран арга 2-р бүлэг



Энэ бүлэг нь дээр үеэс «Түүнчлэн ирсний насны хэмжээ 16-р бүлэг»-ийн хамт Цагаан лянхуа судрын хамгийн чухал хэсэг гэгдэж ирсэн. Яагаад тийм чухал болоход анхаарал хандуулангаа энэ бүлгийн ерөнхий агуулгыг үзэцгээе.

Удаан хугацаанд бясалгалд орсон байсан Шагжамүни будда бясалгалаа дуусгамагц хэний ч асуултыг хүлээлгүй шууд сургаалаа айлдаж эхлэв. Эхлээд Шагжамүни будда “Бурханы билиг оюун гэдэг зүйл маш гүн гүнзгий бөгөөд сансар огторгуйн туйлын үнэн хуулийг гэгээрсэн болох” түүнчлэн “Тэр туйлын үнэн хууль нь маш гүн гүнзгий бөгөөд энгийн хүмүүс ойлгохгүй тул өнөөг хүртэл хүмүүсийн ойлгох чадварт тааруулан олон янзын аргаар сургаалаа айлдаж ирсэн. Улмаар хүмүүс тодорхой хэмжээнд аврагдсан боловч хэн ч тэдгээр сургаалын цаана орших жинхэнэ санааг ухаараагүй болох”-ыг айлдана.

«Арван тэгш чанар» ба «Нэг бодол гурван мянган ертөнц»

Ийнхүү айлдаад Шагжамүни будда дуугаа хураачихдаг байна. Тэгээд хэсэг хугацааны дараа дахин ам нээж, ийнхүү айлдана.

“Шаарийбуу, ерөөсөө больё. Үүнийг тайлбарлаад ч ойлгохгүй гэж бодож байна. Яагаад гэвэл миний гэгээрсэн жинхэнэ үнэний хуулийг зөвхөн Бурхан л ойлгоно. Тэр нь ямар

хууль вэ гэвэл энэ ертөнцийн бүх юмс үзэгдэл өөрийн гэсэн дүр төрх, шинж чанар, бие (ил харагдах бие), хүч (далд төрөлхийн чадвар)-тэй байх ба тэр далдын хүч нь янз бүрийн үйл хөдлөл хийж, түүний шалтгаан ба нөхцлөөс шалтгаалаад олон янзын үр дүн, нөлөө үүсдэг. Эдгээр өөрчлөлт нь цорын ганц хуулийн дагуу явагддаг ба бодитоор өөр өөр харагддаг боловч үнэндээ дүр төрхөөс авахуулаад нөлөө хүртэлх өөрчлөлт нь ганцхан хуулийн дагуу явагддаг гэдгээрээ адилхан (эх эцсийн хязгаар) гэсэн үг юм.”

Үүнийг «Арван тэгш чанар» гэх ба «Цагаан лянхуа судрын товчлол» ч гэж хэлдэг. Мөн «Хамаг юмсын жинхэнэ дүр төрх» гэдгийг дэлгэрэнгүй илэрхийлсэн сургаал юм. Энэ сургаалыг хүний амьдрал дээр аваад үзэх юм бол дараах байдлаар тайлбарлаж болно.

Нэгдүгээрт, хүмүүс бидэнд өөрийн гэсэн онцлог чанар байдаг. Өөрөөр хэлбэл өөрийн гэсэн дүр төрх, чанар, биетэй байдаг гэсэн үг. Тэгээд тэр дүр төрх, чанар, биеийн онцлогтоо таарсан хүч чадвар, үйл хөдлөлтэй байдаг. Гэхдээ эдгээр нь өөрчлөгдөшгүй зүйл гэсэн үг биш ба яаж ч хувирч, өөрчлөгдөж болно.

Бид төрөлхийн зан чанарыг “яаж ч өөрчлөх гээд нэмэргүй зүйл” гэж боддог боловч тийм биш юм. “Шалтгаанд таарсан нөхцөл байх л юм бол түүнд тохирсон үр дүн, нөлөө гардаг тул төрөлхийн зан чанар гэдэг өөрчлөгддөг зүйл” гэдгийг энэ «Арван тэгш чанар» сургаал сургадаг байна.

Тиймээс хүнд Бурханы түвшинд хүрэх боломж байдаг бол эсрэгээр тамд унах ч боломж байдаг гэсэн үг. Үүнийг буддизмын Тэндаи урсгалын их багштан улам задлан «Нэг бодол ба гурван мянган ертөнц» сургаалаар тайлбарласан байдаг. Сэтгэл ямар байхаас шалтгаалаад гурван мянган ертөнц (янз бүрийн ертөнц) бий болдог ажээ. Тиймээс энэ «Арван тэгш чанар» болон «Нэг бодол ба гурван мянган ертөнц» сургаалыг ойлгож чадах юм бол “өөрийгөө яагаад ч өөрчлөх боломжгүй” гэж бодож байсан бол “Харин ч яаж л бол яаж өөрчилж болох юм байна. Бүр бурханы гэгээрэлд ч хүрч болох юм байна” гэдгийг ойлгоно. Ийм сайхан зүйл гэж үгүй. Бидний



амьдрал тэс өөрчлөгдөж, гэрэл гэгээгээр дүүрч, цаанаасаа л “за хийгээд байдаг байжээ” гэсэн эрч хүч ундран гарч ирнэ. Эртнээс «Арван тэгш чанар» сургаалыг «Цагаан лянхуа судрын товчлол» гэж хэлж, чухалчилж байсан нь ийм учиртай.

Гэвч энэ «Арван тэгш чанар» сургаалыг Шагжамүни будда ингээд гэнэт айлдахаар тухайн үеийн хүмүүс амьдрал дээрээ тусган бодох сөхөө ч байгаагүй юм. Маш хэцүү сургаал байсан тул зүгээр л яахаа мэдэхгүй хөшиж орхисон байна.

Дээр нь Шагжамүни будда өнөөдрийг хүртэл айлдаж ирсэн уран аргын сургаал (тухайн хүн, тухайн нөхцөл байдалд таарсан сургаал) нь ч гэсэн бурханы билиг оюунаас гарч ирсэн юм хэмээн уран аргын чухлыг онцлон айлдаж эхэлдэг байна.

Ийнхүү Бурханы гэгээрсэн хамгийн дээдийн жинхэнэ үнэний хуулийн талаар айлдаж байна уу гэтэл гэнэт эсрэгээр амьдралд ойрхон уран аргын сургаалыг магтаад байхаар хүмүүс бүр ч ойлгохоо байж эхлэв. Энэ хоёр ямар холбоотой юм бол хэмээн толгойгоо гашилган байв.

Гурван удаа татгалдаж, гурван удаа гуйсан нь

Шаарийбуу тэвчихээ байгаад учрыг асуутал Шагжамүни будда “Түүнийг тайлбарлах юм бол эсрэгээр олон хүмүүс эргэлзээ төөрөгдөлд автагдаж магадгүй тул тайлбарлаагүй нь дээр” хэмээн хариулахаас татгалзав. Ийнхүү Шагжамүни будда гурван удаа татгалзсан боловч Шаарийбуу шалан гуйсаар байсан байна.

Шагжамүни будда ч гэсэн хэн ч асуугаагүй байхад шууд энэ сургаалаа айлдсан нь угаасаа энэ сургаалыг хэлж өгөхгүй бол болохгүй гэсэн сэтгэл байсан болохоор юм. Тэгсэн мөртлөө ийнхүү татгалзсан нь үнэндээ хүмүүст анхааралтай сонсьё гэсэн сэтгэлийн бэлтгэлийг бий болгох зорилготой байсан юм. Тэгээд Шаарийбуу үнэн сэтгэлээсээ гуйж, хүмүүс ч гэсэн сургаалыг анхааралтай сонсьё гэсэн сэтгэлтэй болсныг хараад сургаалаа айлдаж эхлэхээр шийдсэн байна.


Таван мянган шавь нар яван одсон нь

Тэгтэл яасан гэхээр Шагжамүни буддаг ам нээв үү үгүй юү тэнд байсан таван мянган хүн гэнэт босоод яваад өгсөн байна. Шагжамүни будда түүнийг харж байсан боловч хориглосонгүй. Тэгээд тэдгээр хүмүүсийг явсны дараа дахин сургаалаа айлдаж эхэлсэн байна.

Бурханы мэндэлсэн хамгийн чухал шалтгаан Нээх, үзүүлэх, гэгээрүүлэх, оруулах

Тэр сургаалынх нь хамгийн чухал хэсгийг тайлбарлая. “Бурхан цорын ганц чухал зорилгын төлөө энэ ертөнцөд мэндэлдэг. Тэр нь ямар зорилго вэ гэхээр “нээх” буюу хамаг амьтан, юмс үзэгдлийн жинхэнэ дүр төрхийг нэвт хардаг бурханы билиг оюуныг ойлгуулж, хүмүүсийн нүдийг нээж, цэвэр ариун сэтгэлтэй болгох юм. Мөн “үзүүлэх” буюу тийм бурханы билиг оюун нь ямар гүн гүнзгий, уудам болохыг бүх хүмүүст үзүүлэхийн төлөө юм. Мөн “гэгээрүүлэх” буюу тийм бурханы билиг оюуныг өөрийн туршлагаар дамжуулан бүх хүмүүсийн бие сэтгэлд нь шингэтэл гэгээрүүлэх юм. Мөн “оруулах” буюу тийм бурханы билиг оюуныг олох зам мөрд бүх хүмүүсийг оруулах юм. Хамаг бурхад ийм цорын ганц чухал зорилгын төлөө ертөнцөд мэндэлдэг юм.”

Ийнхүү Шагжамүни будда анх удаа бурхад ертөнцөд мэндлэх хамгийн чухал зорилгыг хэлж өгдөг байна.





Гурван хөлгөнөөр Нэг хөлгөнийг тунхагласан нь

Үргэлжлүүлээд Шагжамүни будда “Гурван хөлгөнөөр Нэг хөлгөнийг тунхаглах” буюу ширваганы хөлгөн, брадэбудагийн хөлгөн, бодисадвагийн хөлгөнөөр дамжуулж Нэг хөлгөний талаар айлдана.

“Дүгнээд хэлэх юм бол хамаг бурхад зөвхөн бодисадвад сургаал айлддаг юм. Сургаалаа янз бүрийн аргаар айлддаг нь ч гэсэн хамаг юмсын жинхэнэ дүр төрхийг гэгээрэх бурханы билиг оюуныг хүмүүст гэгээрүүлэхийн төлөө юм. Бурхадын хамгийн гол зорилго нь энэ юм. Түүнчлэн ирсэн нь «бүх хүмүүсийг эрх тэгш бурханы түвшинд хүргэх» гэсэн ганцхан зорилгын төлөө хүмүүст сургаалаа айлддаг. Энэ нь л цорын ганц үнэн юм. Угтаа хоёр хөлгөн, гурван хөлгөн гэсэн ялгаа байхгүй юм.”

“Би өнөөдрийг хүртэл «та нар заавал бурханы гэгээрэлд хүрч чадна» гэж хэлж байгаагүй. Яагаад гэвэл хэлэх цаг нь болоогүй байсан юм. Харин одоо хэлэх цаг нь болсон тул хамгийн дээдийн сургаал болох Их хөлгөний сургаалыг айлдахаар шийдсэн билээ.”

“Миний айлдаж байсан олон янзын уран аргын сургаал «Есөн төрлийн сургаал (Бага хөлгөний сургаал)» бол хүмүүсийн ойлгох чадварт тааруулан айлдсан сургаал юм. Тэдгээр нь Их хөлгөний сургаал руу орох бэлтгэл байсан. Одоо бол цэвэр ариун, уян хатан сэтгэлтэй, жинхэнэ үнэнийг байгаагаар нь хүлээж авдаг, бурханы айлдах сургаалыг зөв хэрэгжүүлдэг хүмүүс олон болсон тул Их хөлгөний сургаалыг айлдах болно.”

“Жишээлбэл суваргад мөргөн, ганц удаа «Бурханд залбиран мөргөө» гэж хэлэх төдийд, эсвэл жоохон хүүхэд тоглоомоор газар дээр модны мөчрөөр бурхан зурах төдийд тэр нь бурханы гэгээрэлд хүрэх нөхцөл болдог. Энэ мэт үйлдэл нь нэг харахад хэрэггүй зүйл мэт боловч үнэндээ үүгээр дамжуулж хамгийн дээдийн жинхэнэ үнэний зам мөр буюу «бурханы гэгээрэлд хүрэх зам мөр»-д орсон гэсэн үг юм. Тиймээс уран арга гэдэг зүйлийг яасан ч үл тоомсорлож болохгүй. «Уран арга өөрөө жинхэнэ үнэн» гэдгийг мартаж

болохгүй.”

“Тиймээс миний өнөөг хүртэл дээргүй жинхэнэ үнэнд тулгуурлан айлдаж ирсэн «Есөн төрлийн сургаал»-ыг байгаагаар нь хүлээн авч, цэвэр ариун сэтгэлтэй болсон та нар «бурханы гэгээрэлд хүрэх зам мөр»-д орсон нь ойлгомжтой. Та нар бүгд бодисадва юм. Энэхүү жинхэнэ үнэнийг ухаарч, туйлын ихээр баярлах сэтгэл төрөх аваас та бүхэн ирээдүйд заавал бурханы гэгээрэлд хүрч чадна.”

Ийнхүү айлдсанаар энэ бүлэг төгсдөг.

Нивано Никкёо “Лянхуан Гурамсан Сударын бүлэг тус бүрийн тайлбар /шинэ хэвлэл/”, Косей хэвлэлийн компани, 2016, X 33-42






Жинхэнэ өөрийгөө олох

10-р сар болохоор биеийн тамирын өдөрлөгийн улирал, ном унших, ногоо болон усан үзмийн ургацын улирал, мөн сүнсний баяр зэрэг санаанд орж байна. Манай байгууллагын хувьд бол Оэшики-Нэг хөлгөний баяр болон Үүсгэн байгуулагчийн төрсөн нутгийн баярыг хамгийн түрүүнд бодох хүн олон болов уу. Нэмж хэлэхэд энэ жил Сан-Антонио хэсгийн бурхан залах ёслол гэсэн баярт үйл явдал бас тохиож байгаа билээ.

Гэхдээ хамгийн чухал үйл явдал бол “Үүсгэн байгуулагчийн нирваанд орсон өдрийн номын хурал” юм. Үүсгэн байгуулагчийн оршуулгын ёслолоор ерөнхийлөгч “Үүсгэн байгуулагч бол Шагжамүни буддатай ижил зорилгоор амьдралыг туулсан” хэмээн магтан дурссан байдаг. Үүсгэн байгуулагч “Аль болох олон хүн Цагаан лянхуа сударт айлдсан хүмүүний амьдралын талаар ойлгож, жинхэнэ аз жаргалыг олоосой” гэсэн хүслээр РКК байгууллагыг үүсгэн байгуулсан ба энэ үгэнд түүний дээрх чанар агуулагдсан байдаг.

Энэ сар Үүсгэн байгуулагч шиг сэтгэлтэй байж, жинхэнэ өөрийгөө олох (бурханлаг чанараа олж нээх)-ийн төлөө өөдрөг сэтгэлээр хичээцгээе.

РКК, Олон улсын хэлтсийн дарга
Саитоо Коичи



🌸 RISSHO KOSEI-KAI INTERNATIONAL BRANCHES 🌸

✉ Welcome comments on our newsletter Living the Lotus: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp